МОНГОЛЫН
ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



# 2010: ЖИЛИЙН ТАЙЛАН
# ANNUAL REPORT



# Эрхэм гишүүд, дэмжигч, хамтран ажиллагч нараа




Удирдах зөвлөлийн дарга
Р.Янжмаа
R.Yanjmaa, Chairperson of
AI Mongolia



Хяналтын зөвлөлийн
дарга Д.Энхбаяр
D.Enkhbayar, Head of
Monitoring Counsil

**2010 онд хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд бидэнтэй хамтран болон дэмжин ажилласан та бухэнд талархаж байгаагаа илэрхийлье.**

2010 он нь хүний эрхийн хамгаалагчид болоод эрхээ хамгаалах гэсэн иргэд өөр хоорондоо нэгдсэн, дэмжигчдийн хүрээгээ өргөтгөсөн, үйл ажиллагаандаа технологийн шинэ ололтыг ашиглаж тухайлбал хэвлэл мэдээллээр үнэнийг өгүүлэх, хүний эрхийг хүндэтгэхийг шаардсан жил боллоо.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагын хувьд ч хүний эрхийн үндэсийн үндэс суурь болсон амьд явах эрхийг тэр дундаа цаазаар авах ялыг халуулах кампанит ажил дээрээ түлхүү анхаарч ажиллав.

Шударга ёсыг тогтоох, бүх хүнд эрхийг тэгш эдлүүлэх чиглэлээр ажилласан үйл ажиллагаанд маань гар бие, хүч хөдөлмөр, мэдлэг чадвараа дайчлан оролцсон гишүүд, сайн дурынхан, дэмжигчид тэр дундаа хүний эрхийн төлөө тууштай тэмцэгч залуучуудын хүчээр Монголын Эмнести Интернэшнл энэхүү илтгэлд дурдсан амжилтандаа хүрч чадсан билээ.

Хариуцлага тооцох, шударга ёсонд учирдаг саад бэрхшээлүүдийг арилгах талаар 2010 онд тодорхой дэвшлүүд гарсан боловч ядуурал гүнзгийрч, ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийн тоо улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь биднийг хүрсэн амжилтаараа бахархаж суух биш, улам бүр идэвхитэй далайцтай ажиллахыг шаардаж байна.

Эмнести Интернэшнлийн 50 жилийн ой тохиох 2011 онд хүнийг эрхэмлэн дээдэлж, ядуу тарчиг байдлыг арилгахын төлөө Засгийн газрууд, түүний дотор Монголын засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангахад болоод хүний эрхийн боловсролын асуудалд илүү түлхүү анхаарч ажиллана. Хүний эрхийг хамгаалахад хүн бүрийн оролцоо маш чухал. Ирэх онд мөн адил биднийг дэмжин, хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Монголын Эмнести Интернэшнл



# Dear members, supporters, partners and friends,



Гүйцэтгэх захирал
Б.Алтантуяа

B.Altantuya, Executive director

**We would like to express our deepest gratitude to you for working with us as well as supporting our work for protecting and promoting human rights in 2010.**

2010 was an excellent year! We witnessed the magnificent collaboration of our human rights defenders who expanded their respective circle of supporters, utilized new technologies in our activities to impart knowledge and respect for human rights.

In 2010 Amnesty International Mongolia (AIMn) prioritized the right to life, which is the foundation of some of our early human rights work, especially the campaign to abolish the death penalty. We built fruitful partnerships, for example the formation of a network of international and national supporting organizations.

AIMn successfully achieved everything that is touched on within this annual report of 2010. This would not have been possible without the many members, volunteers and supporters who donated their enthusiasm, time, knowledge and skills. We wish to thank everyone wholeheartedly for their efforts, especially the young people who have worked tirelessly and brought with them a special energy, dedication and passion to our human rights work.

Although we have seen clear progress in eliminating the problems we encounter for social justice unfortunately the number of people living in poor conditions around the world is on the rise. This encourages us to work harder every day; we will not become complacent about our achievements.

In order to mark the 50th anniversary of AI in 2011, AIMn will focus more on human rights education (HRE) as well as holding governments to account, particularly the government of Mongolia by influencing it to be more transparent and responsible for its activities to uphold rights and help eradicate poverty.

Everybody's participation and involvement is vital to protecting human rights and so we look forward to gaining more support and building more partnerships to enrich our activities in 2011.

Amnesty International Mongolia



# 2010 ОНЫ НОМ ТОВХИМОЛ
# PUBLICATIONS IN 2010



The Wire newsletters



Human Rights Eduction through Citizenship Education



Disposable Labour: Migrant Rights in South



Gender Trap



Corporate Accountability Gap



Demand Dignity



Slums



MDG: Half hearted, half measured



Annual Report 2010



Where should I go from here? The legacy of July 1st 2008 riot in Mongolia



Work Experience of the Council for Improving Livelihoods















Монголын Эмнести Интернэшнл нь 17 бүлгийн 1800 гаруй гишүүд, Удирдах зөвлөлийн 9, Хяналтын зөвлөлийн 3 гишүүн, мөн Гүйцэтгэх товчооны 5 ажилтан, Австралийн залуус Хөгжлийн төлөө хөтөлбөрийн сайн дурын 1 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явууллаа.

AIMn has 9 board members, 3 monitoring council members, 5 executive committee staff and 1 volunteer from the Australian AYAD program. AIMn has over 1,800 members and 17 groups.

## ГАРЧИГ

КАМПАНИТ АЖЛУУД

* Цаазаар авах ялыг халах
* Хүнийг хүндэл
* Улс орнуудын төлөө
* Эрүүдэн шүүхийн эсрэг
* Залуучууд хүний эрхийн төлөө
* Хүний эрхийн боловсрол
* Эмэгтэйчүүдийг хүчирхийлэхийн эсрэг

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2009 ОНЫ АУДИТ

2010 ОНЫ АМЖИЛТ

## CONTENT

CAMPAIGNS

* Against death penalty
* Demand dignity
* Country action programm
* International justice
* Youth in human rigths
* Human rigths education
* Voilence against women

INSIDE AI MONGOLIA

FINANCIAL REFORT

AUDIT REFORT 2009

SUCCESS IN 2010



# ЦААЗААР АВАХ ЯЛЫГ ХАЛАХ

НҮБ-ын суурин төлөөлөгчийн газартай хамтран холбогдох төрийн байгууллага, ТББ-ынханд Монгол улсад цаазаар авах ялыг халах асуудлаар зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Узбекстаны Цаазаар авах ял, эрүүдэн шүүхийн эсрэг Эхчүүдийн хөдөлгөөн, Италийн Сант Эжидио нийгэмлэг, АНУ-ын Нью-Йорк хотын "Хохирогчдын гэр бүл" байгууллагын гишүүд тус тус айлчилан хүний эрхийн идэвхитэн, иргэний нийгмийн байгууллагын гишүүд, дэмжигчид, УИХ-ын гишүүд, Нийслэлийн шүүгч, эрдэмтэн судлаач, элчин сайдын яамтай уулзалт хийж, их дээд сургуулийн 500 гаруй оюутнуудад лекц уншлаа.

Монгол улс дахь цаазаар авах ялыг халуулах, дэмжигчдийн хүрээг тэлэх, олон нийтийг гэгээрүүлэх, гүйцэтгэлийг тойрсон нууцлалтай холбоотой асуудалд хэвлэл мэдээллийн анхаарлыг хандуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго тавин ажиллалаа

"Амьдралын төлөөх хотууд-Цаазаар авах ялын эсрэг хотууд" дэлхийн өдрийг анх удаагаа тэмдэглэн Улс төрийн Хэлмэгдэгсэдийн хөшөөг гэрэлтүүлэх, лаа асаах ажиллагааг зохион байгуулав.

"Хүний эрх ба цаазаар авах ял" сэдвээр онол практикийн бага хурлыг MN 25, цаазаар авах ялын тухай судлаачид үзэл бодлоо илэрхийлсэн "Миний блог" нэвтрүүлгийг Боловсрол сувгаар, "Үхдэл явж байна" ...зэрэг цаазаар авах ялын тухай өгүүлсэн кинонуудыг телевизийн сувгуудаар олон нийтэд хүргэж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага өгөх, өдөр тутмын сонин, цахим хуудас, блогоор мэдээ мэдээлэл нийтлэл бичиж ойролцоогоор 1 сая орчим хүмүүст хүргэлээ. Олон нийтэд цаазаар авах ялын талаар сэтгүүлч, хуульч нарт сургалт, семинар зохион байгуулж, Эрдэнэт хотод кино хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ЭИ-ийн ОУ-ын төвөөс УИХ-ын даргад хандан гаргасан цахим ажиллагаанд 384 хүн хамрагдаж, ЭИ-ийн Австри, Бельги, Их Британи, Канад, Франц, Герман, Итали, Япон, Испани, Норвеги, Нидерланд, Португаль, Швейцарийн секцүүд УИХ-ын гишүүдэд хандан гарын үсэг цуглуулах, онлайн үйл ажиллагаа зохион байгууллаа. УИХ-ын гишүүдэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2-р Нэмэлт Протоколд нэгдэн орохыг уриалан 370 гаруй ил захидлыг илгээгээд байна.
Цаазаар авах ялын эсрэг Дэлхийн 4-р Конгресст Монгол улсын төлөөлөгчид оролцож, цаашид энэ ялыг Монгол улсад бүрэн халахаа мэдэгдсэн юм.



Түүнчлэн 2-р Нэмэлт Протоколд нэгдэн орох тухай хуулийн төсөл УИХ-д өргөн баригдахаар боллоо. Тайвань, Иран, Япон улсыг цаазаар авах ялыг хэрэглэхгүй байхыг шаардсан захидал уриалгад дэмжигчдийн гарын үсэг цуглуулж, илгээлээ.

Цаазаар авах ялын талаарх хамгийн сүүлийн үеийн тоо баримт, мэдээллийг багтаасан баримт бичгийг 1000 гаруй хувь хэвлэн гаргаж, олны хүртээл болголоо.

# AGAINST THE DEATH PENALTY




AI Mongolia organized a myriad of activities in 2010 to abolish the death penalty such as consultative and lobby meetings with relevant state agencies as well as the NGOs in cooperation with the UN Resident Coordinator's Office. Members and human rights defenders from the "Uzbekistan's Mothers' Force Against the Death Penalty and Torture", "Sant Egidio Community" in Rome, Italy and the "Victims' Family" in New York, USA visited Mongolia and had meetings with members of Parliament, journalists, lawyers, judges, students, law school teachers, Police Academy students, human rights defenders, researchers and the public. More than 500 students were involved in the lectures delivered by these visitors.

For the first time in Ulaanbaatar, AIMn celebrated "Cities for Life Day - Cities Against the Death Penalty" organized by the Press Conference. This entailed lighting up candles and a monument for victims in cooperation with supporters.

- Influence the Mongolian government to abolish the death penalty
- Educate and disseminate information about the death penalty to better engage civil society in relevant discussion
- Increase the Media coverage and press releases related to the secrecy surrounding death sentences.

AIMn delivered messages against the death penalty to almost one million people using the media consisting of local newspapers, TV stations, blogs and web pages. A conference on the theory and practice of Human Rights and the Death Penalty was broadcasted live on MN25 TV station, a program called "My Blog" where researchers expressed their points of view about the death penalty on their Education TV segment.

They also featured films such as "Dead Man Walking" on different TV stations which was very useful to support AIMn's awareness raising campaign against the death penalty. Additionally, in order to educate the public about the adverse consequences of the death penalty AIMn conducted training and seminars to journalists and lawyers and held a forum about the film in Erdenet city. State delegates who attended the forth World Congress Against the Death Penalty in February in Geneva delivered the Mongolian President's message that Mongolia would take all possible measures to abolish the death penalty in the future.



Thanks to the impact of AI Mongolia's advocacy work, the draft to ratify the Second Optional Protocol to the ICCPR, aimed at the abolition of the death penalty, was discussed and approved by the Standing Committees and will soon be introduced to the Parliament.
Over 370 postcards were sent to the Members of Parliament calling to ratify the Second Optional Protocol by citizens of Mongolia. In addition to this, over 384 e-mails were sent to the Speaker of Parliament and AI sections of Austria, Belgium, UK, Switzerland, Canada, France, Germany, Italy, Japan, Netherlands, Norway, Spain and Portugal. The signatures were collected via petitions and sent to Japan, Iran and Taiwan authorities urging them to abolish the death penalty also. Over one thousand hard copies of material pertaining to death penalty statistics around the world were published and distributed to the public.

# ХҮНИЙГ ХҮНДЭЛ






Ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүст өдөр бүр тулгарч байдаг алагчлал, нийгмийн халамж хамгаалал хүртэх болон үгээ хэлэх боломжгүй байдлыг арилгах, Ядуусын хороолол, Эхийн эндэгдэл, Компаний хариуцлага, НҮБ-ын Мянганы Хөгжлийн Зорилтуудад анхаарал хандуулан ажиллаж байна.

Монгол улс нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт Протоколд нэгдэн орсон Ази тивдээ анхны дэлхийд хоёр дах орон боллоо. Нэмэлт Протоколын дагуу орон байраар хангагдах, хүнс, ус, эрүүл мэнд, нийгмийн халамж болон боловсрол эзэмших эрхүүдийг тухайн улс зөрчсөн тохиолдолд уг эрхээ хамгаалуулахаар НҮБ-д хандах боломжтой юм.

Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр "Нэр төртэй амьдрах гэж юу вэ, Ядуурлаас яаж гарах вэ" зэрэг асуудлаар "Таны үгийг сонсоё" аяныг 2009 онд эхлүүлснээ үргэлжлүүлэн 2010 онд "Нэр төртэй амьдарцгаая" захидал бичих аяныг нийслэл хотод болон орон нутагт өрнүүлж, ядуурлыг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжин, тэдний санаа бодлыг эрх баригчдад хүргэлээ.

Ядуурлын тухай ойлголтыг өөрчлөх "Нэр төртэй амьдарцгаая" жүжгийг Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудаар аялан тоглож, теле зохиомж болгон телевизүүдээр нэвтрүүллээ. Жүжгийн DVD бичлэгийг нийслэлийн болон орон нутгийн нийгмийн, хөдөө орон нутаг дахь Хүний эрхийн хорооны ажилтан, мөн Ази Номхон Далайн бүсийн ЭИ-ийн салбаруудад тус тус хүргэлээ.

Эрх чөлөөний парадын үеэр "МХЗ-д хүний эрхийг дээдлэе" уриалгыг хүргэж, "Сайхан хот, сайхан амьдрал" сэдвийн доор шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар болон "Уур амьсгалын өөрчлөлт ба хүний эрх" сэдвээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг та юу хийж чадах вэ мэдээллийг хүргэлээ.

Орон нутаг болон олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Ядуурлын эсрэг олон улсын өдрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар, Нийслэлийн Халамжийн Үйлчилгээний Газартай хамтран 2 дахь удаагаа олон нийтэд зориулсан нээлттэй өдөрлөг зохион байгуулж тэмдэглэлээ. Энэ нь төрийн байгууллагын нээлттэй ил тод ажиллахыг дэмжсэн, ядуу нөхцөлд амьдарч буй иргэдийг мэдээллээр хангаж чадавхижуулахад чухал алхам болж байна.

Эхийн эндэгдэл, нөхөн үржихүйн эрхийн асуудлаар VSO Английн сайн дурын албатай харилцан үр дүнтэй хамтран ажиллан Жендэрийн тэгш байдал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийн талаарх сургалтуудыг Налайх дүүрэгт 700 гаруй хүмүүст амжилттай зохион байгууллаа.

"Бизнесийн үйл ажиллагаанд баримтлах НҮБ-ын хүний эрхийн хэм хэмжээ" компаний нийгмийн хариуцлагын талаар илтгэл тавьж, "Хариуцлагын заагийг арилгая" гарын авлагыг 600 гаруй пүүс компаний эздэд тараалаа. Хүчээр нүүлгэн шилжүүлэлтийг зогсоох талаар Чад улсын төлөө, Камбож, Лаос улсуудыг Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн олон улсын пактын Нэмэлт протоколд нэгдэх уриалга, эхийн эндэгдэлд анхаарал хандуулах онлайн уриалгад оролцлоо.

# DEMAND DIGNITY

Mongolia has become the first country in Asia and the second in the world to ratify the Optional Protocol to the International Covenant on Economic, Social and Cultural Rights (ICESCR) which allows individuals and groups within the country to seek justice from the United Nations should these rights which include the right to adequate housing, food, water, health, work, social security and education be violated by their government. The Mongolian government welcomes access to the human rights protection mechanisms which is now strengthened nationally and internationally, especially for people living in poverty.




Demand Dignity is an Amnesty International global campaign to stop the human rights abuses that drive and deepen poverty. Focusing on slums, maternal mortality, corporate accountability and the UN Millennium Development Goals (MDGs), the campaign aims to eliminate the discrimination, exclusion, insecurity and voices ignored that people in poverty face each day.

### Public awareness

In 2009 we aimed to collect the `voices` of people on the topic `What does it mean to live in Dignity?`, what poverty is in their opinion, and actions they think will help get one out of poverty. Continuing for another year in 2010, the voices collection has helped to empower people living in poverty and to deliver the voices of rights holders. We will issue a `voices` publication and distribute it to the Government, as well as the UN, and other relevant organizations in 2011 marking the 50th anniversary of Amnesty International.

A play titled "Let`s Live as Human Beings with Dignity", highlighting issues around poverty and dignity was performed in three main cities namely Ulaanbaatar, Darkhan and Erdenet. HRE video clips and the play have been broadcasting on National TV. We produced DVDs of the play promoting public human rights education and will continue to distribute these to social workers and human rights activists throughout the country. They have also been delivered to Amnesty Internationals' sections and structures in the Asia Pacific region.

During the Freedom Parade 2010, we joined more than 2500 people collecting signatures on the petition "Put Human Rights at the Heart of the MDGs" and worked to raise public awareness about the right to adequate housing via a painting and banner `Better cities, Better Life`. Moreover, by raising the profile of the human rights implications of climate change and by highlighting the message '10 things you can do to stop climate change' – we ensure that efforts of governments to meet the MDGs have human rights at their core.

### Local and global partnerships

We strengthened partnerships to promote the protection of the rights of people living in poverty and to raise awareness on economic, social and cultural rights, including recognition of these rights as enforceable and justifiable. This was through collaborating with the City Mayor`s Office and City Social Welfare Service on the International Day for The Eradication of Poverty for the second year in a row. We initiated the collaboration with Government bodies on the principles of human rights based approach which have been included in the government policy and decision.



We forged strong relationships with VSO Mongolia to raise awareness on maternal mortality being a human rights violation and conducted result oriented training about gender equality and reproductive health rights to more than 700 people in the Nalaikh district.
We contributed to the trainings for government agencies and business organizations to make a presentation of UN Human Rights standard for businesses and distributed the manual titled `Corporate Accountability` to more than 600 business entities in the country. We will continue to work urging on corporations to uphold human rights and on governments to hold corporations to account for human rights violations.
Action was taken, both online and offline, to support the global movement to oppose the forced eviction in Chad, petitions were undertaken to call on the governments of Cambodia and Laos to become a party to the Optional Protocol to ICESCR; and online action was taken to "Put human rights at the heart of the MDGs".











# УЛС ОРНУУДЫН ТӨЛӨӨ

“Би эндээс хаачих вэ? 2008 оны 7 дугаар сарын 1-ний Монголд болсон үйл явдлын сургамж” тайланг хэвлэж, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Хууль сахиулах байгууллагууд, Гадаадын элчин сайдын яамд, орон нутгийн хүний эрхийн хорооны ажилтан болон ТББ-уудад хүргэж, зөвлөмжийг хэрэгжүүлэхийг уриалав. НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэгт зориулсан илтгэлийг шинжээчидтэй хамтран бичив.

“Цагаач ажилчдын эрхийн тухай конвенц”-д Монгол улс ба Өмнөд Солонгос улсыг нэгдэж оруулах асуудлаар ГХЯ-нд албан бичиг уриалга илгээв. ОХУ-ын Эмнести Интернэшнлтэй хамтран Онлайн хэлэлцүүлгийг зохион байгуулж, харилцан туршлага солилцлоо.

Орос, Төвд, Хятад, Лаос, Бирм улсуудын хүний эрхийг хамгаалагчдыг яаралтай суллуулах болон Өмнөд Солонгос, Монгол, Малайз улсуудыг Цагаач ажилчдын эрхийн конвенцид нэгдэж орох захидал уриалгад оролцож, нийт 3700 гаруй гарын үсэг зуруулж илгээлээ.





# COUNTRY ACTION PROGRAMM

The report “Where should I go from here? The legacy of July 1st 2008 riot in Mongolia” was published and distributed to the rights holders of Mongolia, President, Prime Minister, Parliament and law enforcement organizations, police, court and foreign embassies and consulates, local human rights workers and NGOs working for human rights. This encouraged all of the aforementioned agencies and individuals to take action on the set of recommendations provided. We forged strong ties with and collaborated with experts of the International Secretary working on the UPR to the UN.

The letter and petition regarding the treaty of the International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of their Families was sent to the Ministry of Foreign Affairs and Trade in Mongolia. The purpose of this letter was to lobby the Mongolian government and South Korean government to adopt the convention.

In Mongolia in 2010, we worked on the release of prisoners of conscience and human rights defenders from Russia, Tibet, China, Laos and Burma; and on the petition for Mongolia, South Korea and Malaysia to adopt the International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of their Families.

The above actions collected more than 3,700 signatures and contributed to the protection of prisoners of conscience and human rights defenders.

- Raise awareness on HRDs and migrant workers protection among the general public
- Increase number of members recruited via the web
- Release and protect prisoners of conscience and human rights defenders.

# 2010 АМЖИЛТ SUCCESS

## 2010 оны 1-р сарын 12 Шри Ланкийн сэтгүүлчийг батлан даалтаар суллалаа

Эмнести Интернэшнл өнгөрсөн жил засгийн газрынхаа явуулж буй бодлогыг шүүмжилсний төлөө терроризмын хэрэгт гүтгэгдэн 20 жилийн ял сонссон Шри-Ланкийн сэтгүүлч Тиссайнаягам суллагдсаныг талархан хүлээн авлаа. Тиссайнаягамыг суллаад зогсохгүй Шри-Ланкийн зэвсэгт хүчнийг шүүмжилсэн нийтлэлүүд хэвлүүлсний улмаас түүнд тулгасан "олон нийтийг хагалан бутаргасан" хэргийг мөн хүчингүй болгохыг Эмнести Интернэшнл Шри-Ланкийн эрх баригчдаас шаардав.

## 12 January 2010 Jailed Sri Lankan journalist released on bail

Amnesty International has welcomed the release on bail of Sri Lankan journalist JS Tissainayagam, who was sentenced to 20 years in jail on terrorism charges last year after criticizing the government. Amnesty International has also urged the Sri Lankan authorities to follow up Tissainayagam's release by quashing his conviction for "inciting communal disharmony" after he published magazine articles critical of the Sri Lankan military.

## 2010 оны 4-р сарын 26 Их Британи терроризмын хэрэгт хилсээр яллагдсан хохирогчид нөхөн төлбөр өгөхөөр боллоо

Их Британийн Засгийн газраас 2001 оны 9-р сарын 11-нд АНУ руу халдсан онгоц барьцаалагчдад сургалт явуулж байсан хэргээр хилсээр ял эдэлж байсан нисэх онгоцны жолоодлогын багш Лотфи Райссид нөхөн төлбөр өгч хохиролгүй болгох шийдвэр гаргасныг Эмнести Интернэшнл талархан хүлээж авав.
2002 оны 4-р сард шүүхээс түүнийг терроризмтой холбоотой гэж үзэх ямар ч нотолгоо олдоогүй гэсэн үндэслэлээр шоронгоос суллах шийдвэр гаргажээ.

## 2010 оны 7-р сарын 7 Далбаа өргөснийхөө төлөө хоригдсон Индонезийн үзэл санааны хоригдол суллагдлаа

Юсак Пакаж Ерөнхийлөгчийн өршөөлөөр суллагдлаа.
Тайван замаар далбаа өргөн эсэргүүцлээ илэрхийлснийхээ төлөө хоригдсон Индонезийн үзэл санааны хоригдлыг сулласан явдлыг Эмнести Интернэшнл талархан хүлээн авлаа.
31 настай Юсак Пакаж нь Папуа мужийн Сентань хот дах Доёо Бару шоронгоос суллагдлаа. Тэрээр 2004 оны 12-р сард болсон тайван жагсаалд оролцон Папаугийн тусгаар тогтнолыг бэлгэдсэн Өглөөний Од (the Morning Star) далбааг өргөж явсныхаа төлөө 10 жил хоригдох ялаар шийтгүүлээд байсан билээ.

## 1 June 2010 Turkish officials convicted over activist's death

Amnesty International has welcomed the conviction of 19 Turkish officials found guilty of causing the death of a political activist in a landmark torture case. Engin Зeber, who was arrested after taking part in a protest against a police shooting of another activist, died after being beaten in police custody and in prison.
The verdict is the first time in Turkish legal history that state officials have been jailed for life for causing death through torture.

## 2010 оны 10-р сарын 13 Молдав Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд нэгдэв

Молдав улс Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг соёрхон баталсан нь хүний эрхийн ноцтой зөрчлүүдийг шийдвэрлэх зүгт хийсэн нааштай алхам боллоо гэж Эмнести Интернэшнл мэдэгдэв. Молдавын Эмнести Интернэшнл болон иргэний нийгмийн бусад байгууллагуудын арван жилийн кампанит ажлын үр дүнд Молдав улс 2010 оны 10-р сарын 13-нд Ромын дүрмийг соёрхон баталсан 114 дэх орон боллоо.

## 26 April 2010
## UK agrees to compensate man wrongly accused of terrorism

Amnesty International has welcomed a move by the UK authorities to compensate Lotfi Raissi, a flight instructor who was wrongly accused of training the hijackers of airplanes used to carry out the attacks on the US on 11 September 2001.

In April 2002, a judge ordered his release, stating that the court had received "no evidence at all" to support the allegation that he was involved in "terrorism".

## 2010 оны 8 сарын 30
## Мексикийн орон нутгийн хүний эрхийн төлөө тэмцэгч хоёр жил шоронд хоригдсоны эцэст суллагдлаа

Эмнести Интернэшнл хоёр жилийн турш хүн амины хэрэгт хилсээр гүтгэгдэн хоригдсон Мексик улсын хүний эрхийн төлөө тэмцэгчийг суллахыг уриалж байсан билээ. Гурреро мужийн шүүгч Раул Хернандезыг цагаатгаж, нэн даруй сулласан байна.

2010 оны 8-р сарын 27-нд "Раул Хернандезыг сулласан нь маш зөв алхам юм.

## 30 August 2010
## Mexican indigenous rights activist released after two years in prison

Amnesty International has welcomed the release of a Mexican indigenous human rights activist who was imprisoned for over two years on a fabricated murder charge.

Raъl Hernбndez was acquitted by a judge in Guerrero State on Friday 27 August and immediately released.

## 13 October 2010
## Moldova commits to international justice

Moldova has taken a welcome step towards tackling gross human rights violations by ratifying the Rome Statute of the International Criminal Court, said Amnesty International. Wednesday's ratification follows more than 10 years of campaigning by Amnesty International Moldova and other civil society groups. Moldova is now the 114th state to ratify the Rome Statute.

## IMPACT IN MONGOLIA

* President of Mongolia announced a moratorium on execution on the 14th of January, 2010 at the State Great Hural.
* Mongolia has become the first country in Asia and the second in the world to ratify the Optional Protocol to the International Covenant on Economic, Social and Cultural Rights.
* On November 11, 2010 Mongolia supported the third UNGA resolution on moratorium on the use of the death penalty
* Ulaanbaatar city joined to the "Cities for life" Day on November 30 2010.
* The big discussion is ongoing on the issue of the death penalty among the lawyers, legislators, researchers, students, public and through Medias across the country.
* AI delivered submission to the UN Universal Periodic Review. UPR's recommendations to Mongolia included the AI's calls that urged Mongolia to ratify the Optional Protocol to the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights aiming at the abolition of the death penalty

Inside organization

* 6 informal new groups built.

## МОНГОЛ ДАХЬ  Р НӨЛӨӨ

* 2010 оны 1-р сарын 14-нд Монгол улсын ерөнхийлөгч УИХ-ын чуулганд цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлж байгаагаа мэдэгдсэн.
* Монгол улс нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт Протоколд нэгдэн орсон Ази тивдээ анхны дэлхийд хоёр дах орон боллоо.
* 2010 оны 11 сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас дэлхий нийтээр цаазаар авах ялаас татгалзах тухай тогтоолыг хэлэлцэж батлахад Монгол улс дэмжсэн санал өглөө.
* "Амьдралын төлөөх хотууд- Цаазаар авах ялын эсрэг хотууд" ажиллагаанд Улаанбаатар хотыг нэгдлээ.
* Орон даяар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бодлого боловсруулагч, хуульч, эрдэмтэн судлаач, хууль зүйн болон бусад сургуулийн оюутан залуучууд, иргэдийн дунд цаазаар авах ялын асуудлаар хэлэлцүүлэг өрнөөд байна.
* Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаархи ЭИ-ийн илтгэл НҮБ-ын ээлжит, дүгнэлт, хуралдаанд танилцуулагдлаа. Монгол улсад хандаж гаргасан зөвлөмжид ЭШЭКНП, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2-р Нэмэлт Протоколд нэгдэн орохыг олон орноос зөвлөмж болгосон байна.

Байгууллага дотооддоо

* Шинээр 6 албан бус бүлэг бий болоод байна.

# ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ



Эрүүгийн хуулийн шинэ төсөлд өгсөн олон улсын төвийн шинжээчдийн зөвлөмжийг тусгуулах болон "Хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх тухай" хуулийн төслийн талаар ЕТГ, ХЗДХЯ-ны хууль өргөн барих ажлын хэсгийнхэн, холбогдох харьяа газруудад санал хүргүүлэн, уулзаж ярилцлаа.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудлыг ХЭҮК, ТББ-уудаар дэмжүүлэн холбогдох байгууллагад санал хүргүүлснээр ХЗДХЯ-ны ажлын хэсэг уг Нэмэлт Протоколд нэгдэн орох нь зүйтэй гэж үзсэн байна.



ХЭХҮХ-ийн хороотой хамтран мониторинг хийх хорих, саатуулах байрыг сонгох асуудлаар Цагдаагийн байгууллага, Хорих байгууллагын удирдлагуудтай хийсэн уулзалтын үр дүнд цагдаагийн байгууллагаас 3 газарт мониторинг хийх зөвшөөрөл олгоод байна.

**Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөл үзүүлэх, түүний Нэмэлт Протоколд нэгдэн орохыг Монгол улсын Засгийн газарт уриалах, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний механизмийг бий болгох, "Терроризмийн эсрэг дайн" нэрийн дор эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдалтай тэмцэх зорилт тавин ажиллалаа**

Эрүүдэн шүүхийн хохирогсдод туслах олон улсын өдрөөр эрүү шүүлтээс хохирсон хүмүүс хаана хандаж өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх болон бусад холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг Хархорин худалдааны төвд зохион байгуулж, 900 гаруй хүнд хүрч, МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Хууль зүйн сайд, Гадаад харилцааны сайд нарт хандсан захидалд иргэдийн гарын үсэг цуглуулан илгээлээ.

2008 оны 7 сарын 1-ний хэрэгт ял завшуулахгүй байхыг сануулсан мэдэгдлийг өдөр тутмын сонинд хэвлүүлэн, холбогдох хуулийн болон хууль тогтоогч байгууллагуудад, ОУ-ын төвийн шинжээчидтэй хамтран НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн эсрэг Хороонд илтгэл хүргүүллээ.

Эмнести Интернэшнл хөдөлгөөний хүрээнд өрнүүлж байгаа терроризмтэй шударгаар тэмцье кампанит ажилд гишүүд, дэмжигчид оролцож, Гуантанамо дахь эрүү шүүлтийн талаар АНУ-ын ерөнхийлөгчид хандсан захидалд 433 гарын үсэг цуглуулж илгээлээ. АНУ-ын ерөнхийлөгч асан Жорж Бушийн эрүүдэн шүүх ажиллагаа явуулсныг нь мөрдөн шалгахыг шаардсан Эмнести Интернэшнлийн мэдэгдлийг өдөр тутмын сонинд хэвлүүллээ.

ЭИ-ээс Судан улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахад анхаарал хандуулан ажиллахыг уриалж ГХЯ-нд захидал илгээснээр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн чуулганаар хэлэлцэгдэх боломжит эерэг алхамуудыг дэмжихээ мэдэгдсэн байна.

# INTERNATIONAL JUSTICE

A meeting was held with the working groups of the Ministry of Justice (MoJHA) and the Office of the President pertaining to the AI IS recommendations and comments to the draft amendment to the Criminal Code.

In terms of significant progress, the working group of MoJHA made recommendations to ratify the OPCAT according to AI Mongolia's comments to MoJHA to do so and establish the National Preventive Mechanism. This included representatives from NGOs and was supported by the Human Rights Commission of Mongolia and human rights NGOs.

The General Police Department agreed to receive monitoring of three custodies after the meeting with officials from the Police and General Authority for Implementing Court Decisions in cooperation with the National Human Rights Action Program Committee.

During the International Day in Support of Victims of Torture, we organized visible actions in public places such as Kharkhorin as it attracts over 900 people during weekends and collected signatures for a letter urging Mongolia to ratify the OPCAT. They were addressed to the President, Prime Minister and Ministers of MoJHA and Foreign Affairs.

In addition to this, we conducted awareness raising activities among the public about our various campaign activities through the Media such as TV, newspapers and web pages.

We published AI's Public Statement about the July riot in Mongolia stating that "Mongolia must not allow impunity for police officials suspected of human rights violations during the 1 July 2008 riot" in the local daily newspapers.

Under the Counter Terror with Justice Campaign, AI Mongolias' members and supporters sent letters expressing their solidarity to the Guantanamo detainees, distributed campaign leaflets and collected 433 signatures for a letter that urging the USA president to bring Guantanamo detainees to a fair trial. AIMn also published the translation of the document "USA: Former President's defence of torture highlights need for criminal investigations" in the daily newspaper.

After they received an official letter from AI Mongolia with the statement from IS, the Ministry of Foreign Affairs informed us to support any positive actions relating to the human rights situation in Sudan during the Human Rights Council session.





• Call for an absolute ban on all forms of torture and other forms of ill treatment • Universal ratification of the Rome statute • National law reform provides victims with effective national tools for justice, truth and reparations "Ratification of the OPCAT and be encouraged to establish an effective, viable NPM"





Залуучуудыг гишүүнээр өргөнөөр элсүүлэх, тэдний хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг дэмжих, Хүний эрхийг орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд хамгаалах, дэмжих эвсэл холбоо, түншлэлийг бий болгох зорилт тавин ажиллаа

# ЗАЛУУЧУУД ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ

### Залуучуудыг эгнээндээ нэгтгэх, идэвхижил, түншлэл

2010 он залуучуудтай их ойрхон ажиллаж, тэднийг хүний эрхийн төлөө үйлсэд татан оролцуулах, тэдний нийгэмд авчрах өөрчлөлт, үр нөлөөг өсгөх арга замыг хайсан жил боллоо. Залуучуудын санал, санаачилгыг дэмжсэнээр залуучууд Эрх чөлөөний Парад, Нэр төртэй амьдарцгаая жужиг, Залуу Петр Бенинсон хүний эрхийн театрын сургалт, "Эрхүүлэй ба түүний нөхөд" аян зэргийг хийн, олон нийтийг гэгээрүүллээ.

Шинэ гишүүдийн 70 гаруй хувь нь залуучууд ба тэд хүний эрхийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд ажиллаж, шинэ болон хуучин түншлэгчидээр эгнээгээ тэллээ.

2010 онд Залуучуудын Эрх Чөлөөний Парадыг зохион байгуулж, 3000 гаруй хүүхэд залуучуудад  ЭИ-ийн кампанит ажлууд болон ЭЗНСЭ-ийн талаар танилцуулга хийлээ.

### Залуучуудын манлайлал, шийдвэр гаргах түвшний оролцоо

2010-2011 оны АНДБЗС-ний Залуу Элч төлөөлөгчөөр бүсийн болон орон нутгийн хэмжээнд Хүнийг хүндэл кампанит ажлын хүрээнд ажиллахаар 3 баг шалгарлаа.

АНДБЗС-ний Залуу элч нар Хүнийг Хүндэл КА-ын хүрээнд жужиг найруулан тоглож, дуу зохион дуулж, тус КА-ын мессэжийг олон түмэнд хүргэн сурталчиллаа. Залуучууд бүсийн болон үндэсний хэмжээнд 1000 гаруй сурагчдад хүний эрхийн сургалт заахад оролцлоо.

Монголын Эмнести Интернэшнлийн гишүүн залуучуудын дунд манлайллын сургалт явуулж, 8 залууд манлайлагчийн сертификат олгов.  Сургалтаа амжилттай төгссөн энэ 8 залуу Дархан, Эрдэнэт хотын 60 орчим хүүхэд залууст манлайллын сургалт хийв. Залуучуудыг үйл ажиллагааны төлөвлөгөө хийх, стратеги бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд оролцуулан дэмжсэнээр тэд Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. АНДБЗС-ний 2010-2012 оны стратеги төлөвлөлтийн уулзалтанд Залуучуудын бүлгийн төлөөлөгч оролцож, бүсийн цаашид баримтлах чиг баримжаа, төлөвлөгөөг боловсронгүй болгох мөн залуучуудыг идэвхижүүлэх боломж, түншлэл, бүсийн хамтарсан төлөвлөгөөг гаргах талаар хэлэлцсэн байна.

# YOUTH IN HUMAN RIGHTS

## Youth recruitment, activism, partnership

In 2010 we worked closely with youth, exploring ways to attract them to our human rights work and to increase the impact of their efforts to make changes in the society.

We ensured that supporting youth initiatives was a priority in 2010 and this is demonstrated by the implementation of several of AIMn's biggest visible public human rights awareness raising events. Some include: the entirely Youth run Freedom Parade, Let's live with Dignity play, Young Peter Beninson Human Rights Education theatre, "Erkhuulei and his/her friends introduction to the UDHR" and Erkhuulei tour.

As youth set a goal to expand our youth membership, almost 70% of the new members were youth. Youth were happy to work on protecting and promoting human rights at the international, national and local level as well as building and strengthening partnerships with existing and new youth organizations such as MonFemNet, Let's develop club, APYN, Child for child, Norwegian Lutheran Mission, Mongolian Student's Union, Mongolian Youth Federation, and UNYAP.
In October, 2010 AIMn youth successfully organized the annual Youth Freedom Parade together with other youth organizations and it attracted over 3000 people and raised awareness of AI campaigns and ESCR through the messages delivered.

## Youth leadership and participation in decision-making processes

In late 2010, there were three teams in total chosen from Mongolia to be APYN Youth Ambassadors to work to promote the Demand Dignity campaign regionally and nationally.

AIMn APYN Youth Ambassadors implemented their action plans within the Demand Dignity campaign successfully and delivered the messages to the general public with a play and a song. Youth facilitated human rights training to over 1000 school children both regionally and nationally as a part of Human Rights Day events and so on.

"The Leadership training" conducted by our first AYAD volunteer from Australia, James Adams, was successful and a Certificate of Completion was issued to eight youth. These youth facilitated Leadership training to sixty young people in Darkhan and Erdenet cities.

Youth were encouraged to participate in the development of our OP, other strategies such as the new Youth Strategy 2010-2016 and have been active members in the decision making processes of our Board and Auditing Council.
A youth group representative participated in the APYP consultation meeting and discussed opportunities to activate and mobilize more youth, partnerships and provided input into the regional operational plan for 2010-2012 along with its strategy.






• Foster membership growth among young people and their active participation in human rights work •Build strategic partnerships and coalitions to support and promote HR locally and globally. • Broaden the scope and possibilities for the participation of our members and supporters in our work, eliminating barriers to active engagement.






Иргэдийн Хүний эрхийн боловсролын түвшин, мэргэжлийн чанарыг дээшлүүлэхийг ЗГ-аас шаардах, Ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийг эрхээ шаардахад нь чадавхижуулах, Шинэ технологийн чадлыг бүрэн дүүрэн ашиглах, Хүний эрхийн боловсролын хүрээнд зорилтот бүлгүүдийг чадавхижуулах чиглэлээр ажиллаа

# ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

## Ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүст эрхээ шаардахад нь туслах

Сургагч багш нараа хот айлын сургалт явуулах чиглэлээр чадавхижуулан, дахин сургалтанд хамруулав. Архангай аймгийн Цэнхэр сумын  хот айлуудад Малчдыг чадавхижуулах 3 удаагийн цуврал сургалт хийж, 80 гаруй иргэд, малчид хамрагдсан юм. Сургалтаар олж авсан мэдлэгтээ түшиглэн сумын иргэд өөрсдөд тулгарсан бэрхшээл, эрхийн зөрчлийн асуудлаараа Сумын засаг дарга, МУ-ын ерөнхий сайдад хүртэл хандсан эрхээ хамгаалах ажлыг зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн байна.

## Шинэ технологийн чадлыг бүрэн дүүрэн ашиглах, тэмцэгчдийн дуу хоолойг өсгөх

Цахим сургалтыг Германы Франкпуртын их сургууль, Германы ЭИ-тэй хамтран зохион байгуулав. Сургалтанд Герман Монгол, Казакстан 3 улсын оюутан 60 гаруй хүүхэд залуучууд хамрагдсанаас Монголоос 25 сурагч, оюутнууд оролцов.

## Хүний эрхэд ээлтэй сургууль

Монгол Энэтхэгийн сургууль дээр уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд  Сургуулийн удирдлага оролцоо,  Хичээлээс гадуурхи үйл ажиллагаа буюу сургуулийн орчин,  Багш сурагч - сурагч багшийн хоорондын харилцааны чиглэлээр  олон сайхан ажил, сургалтыг хийж, багш сурагчдын идэвхи оролцоо нэмэгдсэн байна. Сурагчдын өөрсдийн оролцооны аргаар гаргаж ирсэн “Хүний эрхэд ээлтэй ангийн дүрэм, Эерэг харилцаа зэрэг материал хэвлэгдэн тараагдсан бөгөөд Хүний эрхийг нэгж хичээлээр заах нь уралдаанд тус сургуулийн багш нар бүтээлээ өргөнөөр ирүүллээ.

## Сургагч багш

“ХЭБ-ын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр илтгэл тавьж, БСШУЯ, ХЗДХЯ болон холбогдох бусад газар, албан тушаалтнуудад зөвлөмжийн хамт хүргүүллээ.

Монголын мэргэжлийн нийгмийн ажилтны нийгэмлэг, Баянзүрх дүүргийн ЗДТ газартай хамтран 24 хорооны нийгмийн ажилтнуудад ХЭ-ийн Сургагч багш бэлтгэх сургалт явуулав. БШСУЯ, Нийслэлийн боловсролын газартай хамтран Аймаг, Нийслэлийн албан бус боловсролын арга зүйч, Нийслэлийн сургалтын менежер, Архангай, Өмнөговь аймгийн багш зэрэг 200 гаруй хүнд нийт 7 удаагийн сургалт зохион байгуулсан байна.

Төв аймгийн Хууль зүйн хэлтэстэй хамтарч Сумын захиргааны ажилтан, хүний эрхийн зохицуулагч жижиг дунд бизнес эрхлэгч зэрэг 150 гаруй хүнд  ХЭ-ийн чиглэлээр сургалт явуулсан байна.

“Хүний эрх ба хүүхдийн эрх”, “Хүүхдийн эрх ба чиний эрх” сургалтуудыг Норвегийн тусламжийн байгууллага, “Өсвөрийн 333 сургагч багш бэлтгэх үндэсний хөтөлбөр”-тэй хамтран хийж, 740 гаруй хүүхэд хамрууллаа.

# HUMAN RIGHTS EDUCATION



## Empowering people, living in poverty to know and claim their rights

AI facilitators received capacity building training on how to teach herders' and their local communities about human rights.  AI Mongolia conducted three trainings to herders in the Tsenkher soum of the Arkhangai aimag and over eighty herders participated.  Some people who were involved in the training had successfully asserted their rights and taken action urging the Local Government, Prime minister of Mongolia to better protect their rights. They did this by utilsing the campaign techniques and human rights education tools from the training provided by AI.

Call for the Mongolian government to fulfill the obligations to provide human rights training for key professionals and to ensure access to education that promotes respect for the human rights of all people.



## Human rights friendly school (HRFS)

The Joint Mongolian and Indian school is implementing the above mentioned project on HRFS. This project contributed to the increased number in participation of student and teachers in several activities and training . These included the four following areas such as School Participation and Governance; Community relations; Curriculum and Extra-Curricular domain and school environment.  A human rights friendly classroom procedure and guidelines about friendly communication and treatment were developed by students and are now available for all stakeholders of the school community.  Teachers of the school actively participated in a competition to develop curriculum for integrating human rights into a subject of their choice.

• Call for Mongolian government to fulfill the obligations to provide human rights training for key professions and to ensure access to education that promotes respect for the human rights of all people • Empowering people, living in poverty to know and claim their rights, • Better utlise the potential of technology to empower and amplify the voices of activists and rights-holders.

## Training of trainers

AI Mongolia published a presentation on the "The current situation and challenges of human rights education in Mongolia" and shared this as well as the several recommendations to relevant authorities and agencies.

In cooperation with the Bayanzurh District Government and the Association of Mongolian Social Workers, AI Mongolia conducted two days of Training of Trainers to over twenty-four social workers on ECSR.

In conjunction with the Ministry of Education, Education Agency in City, AI Mongolia conducted training on how to incorporate human rights education into the school curriculum to teachers for formal and informal sectors, secondary school teachers in Arkhangai and Omnogobi aimag, and school curriculum managers of the schools in the Capital City Ulaanbaatar. Over 200 teachers were involved in this training which took place seven times.

Cooperating with the Legal Department of the Tuv aimag, AI Mongolia conducted several HRE training to businessmen, public officials and human rights activists. Over 150 people were involved in the trainings.



Under the Action plan to prepare 333 peer trainers in Mongolia, AI Mongolia cooperating with the Norwegian Lutheran Mission and Union of School Children, AI Mongolia conducted several human rights education training sessions to secondary school pupils and over 750 children were involved the trainings.

## Better utlise the potential of technology to empower and amplify the voices of activists and rights-holders



Cooperating with AI Germany and Frankfurt University of Germany, AI Mongolia organized an online human rights course for over 60 students from Germany, Kazakhstan and Mongolia. Twenty-five students and youth from Mongolia participated and AI Mongolia gained experience in organizing online courses and strengthened its capacity to successfully deliver these.



# ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХИЙЛЭХИЙН ЭСРЭГ







* Кампанит ажлын үнэлгээний баг 2004-2010 онд хийсэн ажлын тайлангийн нэгтгэлийг хэлэлцэж, үнэлгээг боловсруулсан. Жендэрийн урхи гарын авлагыг хэвлүүлж олон нийтэд тараасан болно.
* Эмэгтэйчүүдийн эрхийн тухай Хилийн цэргийн удирдах газар, МҮЭ-ийн гишүүн байгууллагуудын ҮЭ-ийн дарга нарт сургалт явуулсан. Хилийн цэргийн удирдах газар, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Хүүхдийг Ивээх Сантай хамтран ажиллаж, 24 шинэ гишүүн элсүүлсэн.
* Хүний наймааны асуудлаар соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд Хүний наймаа ба боолчлол тараах материалыг хэвлүүлж, Охидод аюулгүй сургууль үйл ажиллагааны үеэр олон нийтэд хүргэсэн. "Сургуулийн орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулах нь" хуульчдад зориулсан сургалтын үеэр Аюулгүй сургууль охидын эрх сэдвээр танилцуулга хийж, гарын авлага тараалаа.

"Охидын төлөөх 6 алхам" уриалганд сурагчдаас 228 захидалд санал гарын үсэг авч БСШУЯ-ны сайд Ё. Отгонбаярт уг ил захидлуудыг уламжлуулахаар тус яамны Бага, дунд боловсролын газрын ахлах мэргэжилтэнд гардуулан өглөө.

# STOP VOILENCE AGAINST WOMEN

* Conducted training about Women`s Human Rights for 250 people from the trade union members at the Border Protection Agency and the Trade Union Federation during the 5th Annual Women's Forum. 950 signatures for the right holders of UN and Scandinavians countries were collected.
* Presented the AI`s petition of Safe schools for Girls to a lawyers training about 'Reducing the human rights violence in Schools' conducted in conjunction with Save the Children and the National Center Against Violence.
* Lobbied to Yo. Otgonbayar, Minister of Education, Culture and Science and delivered 228 letters for a petition to make safer schools for girls. These letters were written by school children, who are representatives of the 'National Program of Junior 333 trainers'.

The Demand Dignity Campgain has focussed on raising awareness about the maternal mortality project. This has highlighted research on women living in poverty in informal settlements and focused on women`s access to sexual and reproductive and maternal health rights.

# БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ






2010 он МЭИ үйл ажиллагааныхаа үр нөлөөг дээшлүүлэх, түншлэлээ бэхжүүлэх, гишүүд дэмжигчдийг хүний эрхийн төлөө үйлсэд татан оролцуулах, хамтран үр бүтээлтэй ажиллах арга замыг хайсан жил боллоо

## Өсөлт ба тогтвортой байдал

2010 онд МЭИ байгууллага цахим, цахим бус үйл ажиллагаа болон кампанит ажил сургалтуудаараа 1000 гаруй шинэ гишүүдийг нэгтгэсэнээр одоо 1800 гаруй гишүүнтэй болоод байна.  МЭИ-ийн шинэ гишүүний сургалт болон танилцуулгыг нийт 26 удаа хийж 972 хүн хамрагдлаа. Байгууллагын тогтвортой байдал, чадавхийг бэхжүүлэхийн тулд бид  олон улсын, үндэсний болон орон нутгийн 30-аад хурал, семинарт оролцож, сургалтанд хамрагдлаа.

Байгууллагын өөрийн хүчин чадлыг үнэлэх үнэлгээг Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөл, бүлгийн ахлагч нар, идэвхитэн гишүүд, шинэ гишүүд, залуусын төлөөлөл, орон нутгийн бүлгийн төлөөллийг тэгш оролцуулан хийснээр 2008 онтой харьцуулбал нийт оноо өссөн дүнтэй байв.  Түүнчлэн  “Сайн дурынхны менежментийн тогтолцоог үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийхэд нийт 4,8 оноотой буюу өссөн үзүүлэлттэй гарлаа.
Гишүүд бүлгүүд хамтран хотын төвийн болон захын дунд сургуулийн сурагчид, багш нар, нийгмийн ажилтнууд, үйлдвэрийн залуус, Их Дээд сургуулийн оюутнууд мөн ард иргэдэд хүний эрхийн хичээл заасназр ЕБ-ын 57, 88, 107 дугаар сургууль, Батлан Хамгаалах Их Сургууль, Хэнтий аймгийн Дадал сумын дунд сургууль, Архангай аймгийн төвд тус тус МЭИ-ийн клубыг байгуулсан байна.

## Ардчилал ба Удирдлага

2010 онд Хүний эрхийн төлөө тэмцэгчдийн оруулсан хувь нэмэр өссөн нь ард иргэдийг хүний эрхийн үйлсэд татан оруулж буй амжилтын нэг юм. 2010 онд МЭИ дэмжигчид, гишүүдтэйгээ байгууллагын ардчиллыг бэхжүүлэх, үр нөлөөгөө нэмэгдүүлэх талаар зөвлөлдөж, МЭИ-ийн Ерөнхий Чуулганаар тус санал, өөрчлөлтүүдийг хэлэлцүүлснээр МЭИ-ийн байгууллагын ардчиллыг хангаж, удирдан зохион байгуулахад гишүүд, дэмжигчдийг өргөнөөр оролцууллаа.

## Ажилтнууд ба Сайн дурынхан

Хүний эрхийн төлөө үйлсэд гаргаж буй үр нөлөөгөө дээшлүүлэхийн тулд МЭИ ажилтнуудынхаа ажлыг тогтмол үнэлж, үр ашигтай байдал болон сайжруулах зүйл юу байгааг олж тогтоодог.

Хүний эрхийн төлөө үйлсэд үр нөлөө гаргахад сайн дурынхны мэдлэг, ур чадвар, урам зориг тун чухал ба МЭИ Сайн дурынхныг ажиллуулах гэрээний дагуу 16 гишүүн гэрээ байгуулснаас 10 нь сонгосон кампанит ажлын хүрээнд ажиллалаа. 2010 онд сайн дурынхны хүний эрхийн төлөө үйлсэд хандивласан хувь нэмрийг цагаар тооцож үзвэл 5520 цаг болжээ.

# INSIDE AI MONGOLIA





## Growth and Sustainability

We recruited over 1000 new Human Rights Defenders both online and offline and now our membership stands at almost 1800. The new members induction training was conducted 26 times to 972 people. About 75% of the participants who received the training were youth. To ensure the sustainability of AIMn we took part in approximately 30 international, 8 regional, national and local meetings, seminars and training.

The AIMn Organisational Strengths Self-Assessment (OSSA) took place in September, 2010 and a representative from each group including youth, long-term activists, board and staff members participated. The main score of the evaluation was higher than the 2008 evaluation showing positive signs of improvement. In accordance with the "Volunteer Management Benchmarking Tool" AIMn evaluated itself on Volunteer Management and scored 4,8.

In 2010, members of the groups visited industries, universities, secondary schools both in rural and urban areas to conduct human rights training to social workers, teachers, students, young people, industry workers and the general public. These activities resulted in 4 clubs that were subsequently set up at secondary schools number 57, 88, 107 and the Academy of Defense. Additionally, two informal groups were set up one in Dadal province, Khentii aimag and one in Arkhangai aimag.

In 2010 we are exploring ways to work together more effectively to further increase the impact of our activities, partnership, and engagement of members for human rights.

## Democracy and Governance

Contributions from Human Rights Defenders increased during 2010, reflecting our continued success in engaging with the community. During 2010 we consulted our supporters about ways to strengthen our democracy. Key changes were subsequently endorsed at the Annual Meeting in December 2010 that will provide more people with opportunities to participate in AI Mongolia's governance.

## Staff and Volunteers

In order to continue improving our human rights impact we regularly evaluate our staff performance in order to monitor challenges, room for improvement areas as well as to reflect on key successes.

The skills, knowledge and enthusiasm that volunteers bring to Amnesty International are essential to achieving a demonstrable human rights impact. According to the procedure to employ volunteers in AIMn, 16 volunteers registered and 10 of which worked with a planned weekly timetable and in their chosen campaigns.

In 2010, we began measuring the contribution-in terms of hours provided- that our volunteers make. So we established that our volunteers contributed 5520 hours of their time.




# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Эмнести Интернэшнлийн Олон Улсын Хөгжлийн багаас (ОУХБ) 2010 оны үйл ажиллагаанд зориулж 118 258$-ийн санхүүжилтийг баталсан. Мөн онд гадаад хэл дээр хэвлэгдсэн хүний эрхийн талаархи гарын авлага болон тараах материалуудыг эх хэлнээ хөрвүүлэн гаргах зорилго бүхий Азийн хэлний хөтөлбөрийн хүрээнд 10 897 ам. долларын санхүүжилтийг олгосон.**

2010 онд Хүний эрхийн боловсрол болон бусад кампанит ажлуудад зориулж нийт 24 693 ам. долларын тэтгэлэг, хандив, санхүүжилтыг хүний эрхийг хамгаалагч гишүүд, дэмжигчид, хамтран ажиллагч хувь хүн, компани, байгууллагуудаас санхүүжүүлсэн байна. Уг санхүүжүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн жагсаалтыг арын нүүрнээс үзнэ үү.

Хүний эрхийг хамгаалагч, гишүүд, дэмжигчдийн зохион байгуулсан сан арвижуулах үйл ажиллагааны үр дүнд нийт 3 590 ам. долларын сан арвижууллаа. Гишүүдийн татвар төлөлтөөс нийт 805 ам. долларын санхүүжилтийг хийжээ.

2010 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар нийт 132 721 ам.долларыг кампанит ажил, хүний эрхийн сургалт, цалин хөлс, офиссын болон бусад зардалд тус тус зарцуулсан байна.
Тайлбар: Дээрхи санхүүгийн тайланг 2010 оны 12-р сарын 10-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэв.

### Өгөөмөр дэмжлэг

2010 онд биднийг дэмжиж тэтгэлэг олгосон, өв үлдээсэн, бэлэн болон бэлэн бус хандив, хамтын ажиллагаагаараа тусласан ялангуяа доорхи байгууллагуудад талархаж байна.

- Нээлттэй Нийгэмлэгийн Хүрээлэнгийн Будапешт дахь салбарын “Хүний эрх ба засаглал” төсөл
- Английн Эмнести Интернэшнлийн гишүүн, Белиндагийн өв
- Монголын эмэгтэйчүүдийн сан
- Норвегийн тусламжийн байгууллага,
- “Асо Пресс” ХХК
- Iresh shop
- Монфемнет ТББ
- Маск продакшн
- Куйза продакшн
- Дуулал студи
- АЭ энд Жааг ХХК
- Монголын сурагчдын холбоо

# FINANCIAL REPORT

**The International Mobilization Team (IMT) has approved USD 118,258 for the funding of 2010’s activities. In the same year, AIMn received USD 10,897 worth of funding from the Asian Language Programme for the translation of human rights information leaflets, manuals and books.**

In 2010, AIMn received USD 24,693 from human rights activists, individuals, members, donors, and supporting organizations for HRE and other campaigns. Please refer to the back page for the supporters list. In addition to all of the above, human rights volunteers, members and supporters have organized many fundraising events. Through these activities we raised USD 3,590. In 2010, USD 805 was collected through the payment of membership fees.

Totally, USD 132,721 was spent on campaigns, training, staff salaries, office costs and other expenses for human rights activities by 10 December, 2010.
* Please note that this report only covers the months from January 1st through to December 10th, 2010.



2009 оны санхүүгийн хураангуй тайлан

| САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ | 2009 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31 Төсөв | 2009 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31 Бодит |
|---|---|---|
| Санхүүжилт | | |
| Сан арвижуулах үйл ажиллагааны орлого | 39,024.50 | 22,212.32 |
| Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт | 118,258.00 | 71,658.00 |
| Олон улсын Хөдөлгөөнөөс олгосон санхүүжилт-Азийн хэлний хөтөлбөр | 11,400.00 | 7,706.86 |
| НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН | 168,682.50 | 101,577.18 |
| Зарцуулалт | | |
| Сан арвижуулах үйл ажиллагааны зардал | 14,260.00 | 8,466.61 |
| Хурал уулзалтын зардал | 8,620.00 | 5,833.03 |
| Цалин хөлс | 53,834.28 | 52,563.89 |
| Офиссын зардал | 16,824.00 | 14,485.47 |
| Кампанит ажил, төсөл хөтөлбөр ба сургалт | 72,047.00 | 42,855.17 |
| Санхүүгийн үйл ажиллагааны зардал | 3,029.00 | 3,253.81 |
| НИЙТ ЗАРДЛЫН ДҮН | 168,614.28 | 127,457.98 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 59,494.89 | |
| Нөөц сан | 13,000.00 | |
| Авлагын эхний үлдэгдэл | | |
| Өглөгийн эхний үлдэгдэл | | |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 25,413.35 |
| Нөөц сан | | 16,900.00 |
| Авлагын эцсийн үлдэгдэл | | 4,383.00 |
| Өглөгийн эцсийн үлдэгдэл | | 82.26 |

Тайланг боловсруулсан ня-бо: Т. Ариунаа

Хянасан гүйцэтгэх захирал: Б. Алтантуяа

Аудит хийсэн аудитор: О. Чулуунбаатар /"SM аудит" ХХК/



Brief Financial Report 2009

| STRACTURE: AMNESTY INTERNATIONAL MONGOLIA | 01 January -31Dec,2009 Budget | 01 January -31Dec,2009 Actual |
|---|---|---|
| Income | | |
| Gross Fundraising Income | 39,024.50 | 22,212.32 |
| Income from the International Movement | 118,258.00 | 71,658.00 |
| Asian Language Programme | 11,400.00 | 7,706.86 |
| TOTAL INCOME | 168,682.50 | 101,577.18 |
| Expenditure | | |
| Fundraising expenditure | 14,260.00 | 8,466.61 |
| Governance and Internal Democracy | 8,620.00 | 5,833.03 |
| Salaries | 53,834.28 | 52,563.89 |
| Office expenses | 16,824.00 | 14,485.47 |
| Campaigns, Trainings and Projects | 72,047.00 | 42,855.17 |
| Financial fees | 3,029.00 | 3,253.81 |
| TOTAL EXPENDITURE | 168,614.28 | 127,457.98 |
| Opening Cash & Bank | 59,494.89 | |
| Reserves | 13,000.00 | |
| Opening receivable | | |
| Opening payable | | |
| Closing Cash & Bank | | 25,413.35 |
| Reserves | | 16,900.00 |
| Closing receivable | | 4,383.00 |
| Closing payable | | 82.26 |

Accountant T. Ariunaa

Director B. Altantuya

Auditor O. Chuluunbaatar (SM Audit Co.,ltd)




## Generous support

AIMn would like to thank everyone who has provided generous support to our organisation in 2010 through donations, bequests and in kind support. In particular, we acknowledge support from the following organizations and individuals:

- Human Rights and Governance Grants Program Open Society Institute in Budapest
- Bequest of Belinda who was member of AI UK
- Mongolian Women's Fund
- Norwegian Lutheran Mission
- Aso press Co.,Ltd
- Irish Shop
- Monfemnet
- Mask production
- Quiza Productions
- Duulal Studio
- AE and JAAG Co.,Ltd
- Federation of Mongolian Secondary School Students




Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44, 10 тоот
Утас/факс: 976-11-324705
Цахим хаяг: aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

МУИС-ын оюутны байр

Залуучууд зочид буудал

5 давхар цайвар ногоон байшин

Бид хэвлэл тутмаасаа 1 төгрөгийг Монголын Эмнести Интернэшнл-д хандивладаг бөгөөд бидний энэ хандив ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ үйлсэд зориулагддаг.